

ТЭМДЭГЛЭЛТ ОЙ

ХЯТАДЫН КОММУНИСТ НАМЫН IV ИХ ХУРАЛ**(Хуралдсаны нь 60 жилийн ойд)**

Хүн төлөлхтөн капитализмаас социализмд шилжин орох эрин үеийг нээсэн Октябрийн социалист хувьсгалын ялалт Дорнодахины дарлагдсан ард түмний нийгэм— улс төрийн амьдралын идэвхжил сэргэлтийг хүчтэй болгосноор Хятадын түүхэн хөгжлийн нэгэн үе эхэлсэн юм.

Дэлхийн бусад олон орны адил Октябрийн хувьсгалын нөлөөн дор Хятадад 20-иод оны үед үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн хүчтэй өрнөв. Энэ үеийн хувьсгалт хөдөлгөөний онцлог нь Хятадын ажилчин ангийн гүйцэтгэх үүрэг нөлөө тасралтгүй өсч байсан явдал юм. 1919 оны «5-р сарын 4-ний хөдөлгөөн»-өөр Хятадын ажилчин анги улс төрийн тэмцлийн тавцанд анх удаа гарч ирж, маш богино хугацаанд хувьсгалд идэвхтэй оролцогч хүч болтлоо өсжээ. Ажилчин ангийн хөдөлгөөн тэр үеийн хувьсгалт тэмцлийн гол хэсэг нь болж, түүгээр ажилчдын хувьсгалт идэвх санаачилга илэрч байлаа. Хятадын ажилчин ангийн хувьсгалт тэмцлийг Хятадын Коммунист нам удирдан зохион байгуулж байв. Гэвч ажилчин ангийн биеэ даасан байгууллага бат бэх биш, ажилчдын харьцангуй цөөн хэсгийг хамарч байлаа. Ажилчдын дунд улс төр зохион байгуулалтын ажил явуулж байсан коммунистууд олон түмэнтэй нягт холбоотой болж хараахан чадаагүй байв.

1924 оны сүүлч 1925 оны эхээр Хятадад ажилчин, тариачин хувьсгалт тэмцэлд улс төрийн чухал ахиц гарав. Сунь Ятсений толгойлсон Өмнөд Хятадын засгийн газраас эрх чөлөөний явуулж байсан тэмцлийн үр дүнд Чжилийн милитарист бүлгийнхэн унаж, орон даяар хувьсгал өрнөж эхлэв. 1924 оны 10-р сарын 23-нд У Пэйфу болон Жан Золины хоорондын тэмцэл ид өрнөж Чжилийн нэртэй генералуудын нэг Фэн Юйсян У Пэйфугийн эсрэг тэмцэн, Бээжин хотыг эзэлж, төрийн эргэлт гаргаснаар Английн талыг баримталсан Чжили нар ялагдал хүлээв. Фэн Юйсян империализмын эсрэг Сунь Ятсений уриаг дэмжиж байгаагаар илэрхийлж, өөрийн цэргийг үндэсний арми болгон нэрлэсэн бөгөөд Зөвлөлт засгийн газраас түүний хүссэн ёсоор цэрэг, зэвсгийн болон бусад тусламж үзүүлсэн юм. Үүний зэрэгцээ тэр гоминдануудтай, ХКН-тай харилцаа тогтоосон ба Хойд Хятадад милитаристуудын тогтоосон залхаан цээрлүүлэх дэглэмийг сулруулжээ. Үндэсний арми Хятадын цэрэг улс төрийн амьдралын чухал хүчин зүйл болов. Бээжин дэх эргэлт болон «үндэсний арми» үүсэн бий болсон явдал тус орны хувьсгалт хөдөлгөөн өрнөхөд шууд нөлөөлж, ажилчин ангийн тэмцэл идэвхжин, 1923 оны эхээр хойд, төв хэсэгт тараан устгасан үйлдвэрчний эвлэлийг дахин байгуулах шинэ боломжийг нээсэн юм.¹

1. «Новейшая история Китая», М., 1972, с. 81-82.

Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн өрнөж, ажилчин ангийн тэмцэл идэвхжсэн байдалд ХКН-ын IV их хуралд бэлтгэх ажил явагдаж байлаа. Ийм үед бүх нийтийг юуны өмнө хотын ажилчдыг нэгтгэн зохион байгуулах арга замыг эрж олох, ажилчин ангийн хувьсгалт тэмцэлд гүйцэтгэх үүрэг ролийн тухай асуудал, цаашилбал хувьсгалын үндэстний болон нийгмийн зорилтын хоорондын уялдаа холбооны тухай асуудлыг шийдвэрлэх нь намын өмнө чухлаар тавигджээ.

1920 онд Коминтерний II их хурал дээр В. И. Лениний тавьсан илтгэлд тодорхой заагдсан Дорнодахины дарлагдсан улс орны ажилчин ангийн үндэсний болон ангийн зорилгын уялдаа холбооны амин чухал асуудал олон жилийн турш ХКН-ын өмнө, объектив, субъектив шинжтэй олон тооны бэрхшээлийн улмаас зөв шийдвэрлэгдэхгүй хэцүү төвөгтэй асуудлын нэг болж байлаа. Үүнийг шийдвэрлэх нь Хятадын хувьсгалын нэг зорилт байв.

1925 оны 1-р сарын 14—21нд ХКН-ын IV их хурал Шанхай хотод нууц байдалд хуралджээ. Хурлын ажиллагаанд намын мянга орчим гишүүдийг төлөөлсөн 20 хүн оролцсон байна. Их хуралд Коммунист Интернационалын Гүйцэтгэх Хорооноос (КИГХ) Г. Н. Войтинский төлөөлөгчөөр оролцжээ.

Их хурлаар ажилчны хөдөлгөөний үүрэг зорилт, ХКН-ын зохион байгуулалтын ажлыг сайжруулах, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний өрнөлтийн асуудлыг хэлэлцжээ. Ажилчин ангийг хувьсгалын манлайлагч гол хүчин болох явдал нь намын тэргүүн зэргийн зорилт гэж их хурал үзжээ.

Их хуралд Коминтерний Гүйцэтгэх Хорооны төлөөлөгч Г. Н. Войтинский Дэлхийн коммунист хөдөлгөөний тухай илтгэлийг, ХКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Чэн Дусю Намын Гүйцэтгэх Төв Хорооны илтгэлийг, Коминтерний V их хуралд ХКН-ын төлөөлөгчөөс хийсэн сонголт, түүнчлэн орон нутгийн намын байгууллагуудын илтгэлийг тавьж хэлэлцүүлжээ.

Их хурлаас нийт 11 тогтоол гаргасны дотор Троцкийн байр суурийн тухай, үндэсний хувьсгалт хөдөлгөөн, үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөн, тариачны хөдөлгөөний тухай зэрэг асуудлаар тогтоол оржээ.

Мөн их хурлаас ХКН-ын Дүрэмд өөрчлөлт оруулж, IV их хуралын тунхаг болон В. И. Лениний нас барсны нэг жилийн ойтой холбогдуулан гаргасан мэдэгдлийг сайшаажээ.²

Гоминданы I их хурлаас баталсан империализмын эсрэг үндэсний нэгдсэн фронтын хөтөлбөрийг ажилчин, тариачин ангийн тэмцлийн зорилтуудтай нягт холбон, хөдөлмөрчин олны эрх ашгийн төлөө ангич лоозонг дэвшүүлж ангийн тэмцлийг явуулснаар үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний нийт хүчийг нэгтгэн хувьсгалыг ялалтанд хүргэж болно гэдгийг цохон зааж тэмдэглэсэнд ХКН-ын IV их хурлын ач холбогдол оршино.

Гэвч Хятадын үндэсний хөрөнгөтний дэвшилт зарим хэсгийн хувьсгалч чанарыг бүрэн үгүйсгэж байсан Чэн Дусю, Пэн Шучжи, Чжан Готао мэтийн Төв Хорооны зарим гишүүд «зүүнтний» үзэл санааны үүднээс хурлын шийдвэрийг тайлбарлаж байснаас болж, тус их хурлын дэвшүүлсэн энэ чухал зорилтыг хэрэгжүүлэх явдал мэдэгдэхүйц багасчээ.³

Их хурлаас Төв Хорооны бүрэлдэхүүнд 9 хүнийг, орлогчоор 5 хүнийг сонгожээ.

2. «Проблемы Дальнего Востока», 1975. № 1, с. 123

3. «Проблемы Дальнего Востока», 1975. № 1, с. 123-124

ХКН-ын IV их хурлын түүхэн ач холбогдол нь Хятад дахь үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний асуудалд ажилчин ангийн үзлийн үүднээс хандах явдлыг пролетарийн тууштай интернационализмтэй хослуулан шийдвэрлэсэнд оршино. Хурлын шийдвэрийг удирдлага болгон ХКН өөрийн эгнээг өргөтгөн, олон түмний нам болж, хэдэн сая ажилчин, тариачныг тэмцэлд босгон зохион байгуулж байжээ. ХКН-ын удирдлагын дор Хятадын ажилчин анги хувьсгалт үйл ажиллагааны манлайлагч нь болж байжээ. Ажилчин ангиар удирдуулсан ажилчин, тариачны холбоо, олон улсын коммунист ажилчны хөдөлгөөнтэй нягт холбоотой байх талаар ХКН-ын IV их хурлаас дэвшүүлсэн зарчимч чиг нь цаг үеийн шалгалт сорилтыг даван туулж, ХКН-ын удаа дараагийн баримт бичгүүд, тухайлбал, V, VI VII их хурлын шийдвэрүүдэд тусгагдаж байлаа.

Хятадын ажилчин анги зарим тохиолдолд хүнд ялагдал хүлээж байсан боловч хятадын хувьсгалын үйл явцыг гүнзгийрүүлэн, түүний ялалтыг хангахад чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

Ч. Батцэцэг